



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Г Дотоод, хяналт шалгалт зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/372 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2020 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод, хяналт шалгалтыг зохион байгуулсугай.
2. Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах чиглэл, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн
A/10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117155601
УХА0038 9077073

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДЭД
2020 ОНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Нийслэлийн онцгой байдлын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 дах заалт, тус газрын даргын A/18 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам стандарт, үйл ажиллагааны зорилт, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, бие бүрэлдэхүүний сахилга хариуцлага дэг журмыг сахиулах, илэрсэн зөрчлийг арилгуулахад оршино.

Албаны шалгалтыг хууль, тогтоомжийн хүрээнд хууль дээдлэх, хараат бус, бие даасан, шударга, бодитой, нууц хадгалах зарчимд тулгуурлан явуулна.

Нэг. Хамрах хүрээ

1.1. Нийслэлийн Онцгой байдлын газрын Дотоод хэлтсүүд, нийслэлийн Иргэдийг Гамшигаас Хамгаалах Сургалт Арга зүйн төв, нийслэлийн Аврах анги-105, Дүүргийн Онцгой байдлын хэлтсүүд, Гал түймэр унтраах, аврах ангиуд.

Хоёр. Шалгалт явуулах ажлын чиглэл

2.1. Хяналт шалгалт нь энэхүү журмын 1.1-т заасан зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг тооцох, хяналт тавих, илэрсэн зөрчил түүний шалтгаан нөхцөлийг тогтоох, удирдлагыг бодит мэдээллээр хангах, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны чадавхыг сайжруулахад чиглэгдэнэ.

2.2. Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, тушаал шийдвэр, үүргийн хэрэгжилт.

2.3. Гал унтраах зориулалтын болон аврах ажиллагааны автомашин, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, агуулахын бүртгэл, баталгаажуулалт.

2.4. Гал түймэр унтраах, аврах ангиудын өдөр тутмын цагийн хуваарыг тусгагдсан хичээл сургалт, албаны бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар.

2.5. Гал түймэр унтраах, аврах ангийн томилгоот ээлжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, амьсгалын бие даасан төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон ажилласан байдал, удирдлагаас өгсөн үүрэг чиглэл, хэрэгжилт.

2.6. Сахилга ёс зүй, цэргийн алба, дэг журам, зохион байгуулалтын алдаа дутагдлыг илрүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөвлөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх.

2.7. Алба хаагчдын ажлын цаг ашиглалт, архив албан хэрэг хөтлөлт, бичиг баримтын боловсруулалт, стандартын хэрэгжилт.

2.8. Гамшгаас хамгаалах улсын хяналт, бэлтгэл бэлэн байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын хэрэгжилт.

Гурав. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа.

3.1. Нийслэлийн Онцгой байдлын газраас бүтцийн нэгжүүдэд дотоод хяналт, шалгалтыг сард 2-оос доошгүй удаа ажлын болон амралтын өдрүүдэд шалгаж удирдлагыг бодит мэдээллээр хангаж гүйцэтгэлийг хангуулах.

3.2. Шаардлагатай тохиолдолд мэдээллээр болон удирдлагын шийдвэрээр дотоод хяналт, шалгалтыг явуулна.

3.3. Шалгалтыг дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга удирдан зохион байгуулж шаардлагатай тохиолдолд бусад чиглэлийн мэргэжилтнүүдийг татан оролцуулж хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хяналт шалгалтыг дүгнэх, тайлагнах

4.1. Хяналт шалгалт хийсэн тэмдэглэл, хяналтын хуудсыг шалгалтын бүрэлдэхүүн гарын үсгээр баталгаажуулан, хяналт шалгалтын үр дүнг зохих журмын дагуу мэдэгдэнэ.

4.2 Хяналт шалгалт явуулсан тухай илтгэх хуудас, танилцуулгыг удирдлагад танилцуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

4.3. Хяналт шалгалтын дүн нь нэгжийн хагас, бүтэн жилийн ажлыг дүгнэхэд харгалзах үзүүлэлт болно.

---Оо---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дугээр сарын 02-ны өдрийн
№/р...дугаар тушаалтын хоёрдугаар хавсралт

1117155601
УЖА0038 90777073

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ТАСГААС 2020 ОНД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛ ХУВААРЬ

| № | Шалгах чиглэл | сар | | | | | | | | | | | |
|----|---|-----|---|---|---|---|---|---|---|---|----|----|----|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Гал түймэр унтраах аврах антиудын бэлтгэл бэлэн байдал | | | | | | | | | | | | |
| 2 | 2019 оны жилийн эцсийн шалгалтын зөвлөмжийн биелэлтийн гүйцэтгэлийн хяналт | | | | | | | | | | | | |
| 3 | Алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг дунгасэн байдал, “Цэргийн алба”-ны хэрэгжилтийн хяналт шалгант | | | | | | | | | | | | |
| 4 | Ёс зүйн албаны үйл ажиллагаа, ОБЕГ-ын даргын А/86 дугаар тушаалтын хэрэгжилт. Санхүүгийн үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| 5 | Бие бүрэлдэхүүн, ангиллын сургалтын чанар хүртээмжийн гүйцэтгэлийн хяналт. Алба хаагчдын бичиг баримтын хөтөлөлт эмх цэгц. Хэлтсийн орлогч, гамшигаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтгэн, ахлах байцаагчийн үйл ажиллагаа. | | | | | | | | | | | | |
| 6 | ГТУА антиудын бэлтгэл бэлэн байдал, цаг ашиглалт, зөвлөмж Ууртийн биелэлт | | | | | | | | | | | | |
| 7 | ОБЕГ-аас 2019 онд хийсан иж бүрэн шалгальтын зөвлөмжийн гүйцэтгэлийн шалгант /БЗД, БГД, БНД, ХУД-ийн ОБХ/ | | | | | | | | | | | | |
| 8 | 2020 оны эхний хагас жилийн шалгалтын зөвлөмжийн биелэлтийн гүйцэтгэлийн хяналт | | | | | | | | | | | | |
| 9 | “ХАБЭА дүрэм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдал | | | | | | | | | | | | |
| 10 | Гал түймэр унтраах аврах антиудын бэлтгэл бэлэн байдал, зөвлөмж Ууртийн биелэлт | | | | | | | | | | | | |
| 11 | Бие бүрэлдэхүүн, ангиллын сургалтын чанар хүртээмжийн гүйцэтгэлийн хяналт. Алба хаагчдын бичиг баримтын хөтөлөлт эмх цэгц | | | | | | | | | | | | |
| 12 | Нэгжийн бэлтгэл бэлэн байдал | | | | | | | | | | | | |